



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

"Блүмсбюри секюритиес ҮЦК" ХХК -
ийн арилжаанд оролцох эрхийг сэргээх
тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гүйцэтгэх захирлын 2016 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 183 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Блүмсбюри секюритиес ҮЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2016 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Цаашид хууль тогтоомж, журам заавар болон "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанитай байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлэн ажиллахыг "Блүмсбюри секюритиес ҮЦК" ХХК /Б.Мягмарсүрэн/-д анхааруулсугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шалгалтын алба /Л.Нямдагва/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



М.БОЛОР